

## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

---

### УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРЬСАН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АГУУЛГЫГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

*Судалгааны код:* СТ-15/202  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Б.Гарамгайбаатар  
*Огноо:* 2015.01.15  
*Сэдвийн агуулга:* Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн өнөөгийн байдал, бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоо зэргийг тоймлон судалсанаас гадна УИХ-д өргөн барьсан хуулийн төслийн гол агуулгыг тоймлон харуулж, хөгжлийн бодлого төлөвлөлтийн сайн туршлага бүхий орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсан болно.

### ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН НОГДОЛ АШГИЙН СУУТГАЛЫН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

*Судалгааны код:* СТ-15/408  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын дарга З.Энхболд  
*Огноо:* 2015.04.16  
*Сэдвийн агуулга:* Ногдол ашгийн суутгалын татварын хувь хэмжээг ДНБ-ийн хэмжээ болон нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээгээр тэргүүлэгч 25 орон, Дэлхийн 162 орны ногдол ашгийн суутгалын татварыг хувь хэмжээгээр нь ангилан гаргаж Европын орнуудад оршин суугч болон оршин суугч бус этгээдэд ногдуулах хувь хэмжээний талаар харьцуулсан мэдээлэл, лавлагаа гаргасан болно.

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БОЛОН ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙ САЛБАР ДАХ ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ АСУУДЛЫГ ЭРҮҮГИЙН ХУУЛИАР ЗОХИЦУУЛДАГ ЭСЭХ ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

*Судалгааны код:* СТ-15/222  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Алтан-Оч, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа, Д.Халиун  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл  
*Огноо:* 2015.06.08  
*Сэдвийн агуулга:* Эрүүгийн хуулийн төсөлд тусгагдсан эдийн засгийн зарим төрлийн зөрчил, гэмт хэрэг /шударга бус өрсөлдөөн, хөрөнгийн зах зээлийн

холбогдох зохицуулалт/-ийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хуулиар зохицуулдаг эсэх талаар мэдээллийн хайлт хийж БНХАУ, ХБНГУ, Латви, Литва, Эстони улсуудын эрүүгийн хууль болон бусад салбар хуулиудын зохицуулалт болон Европын Холбооноос 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэн зах зээлийг урвуулан ашиглах гэмт хэргийн талаарх тогтоол, зөвлөмжийг харьцуулан судалсан болно.

## НИЙГМИЙН БОДЛОГО

---

### ХҮҮХЭД АСРАН ХАМГААЛАХ ЭЦЭГ, ЭХИЙН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА” ХАНДЛАГА

*Судалгааны код:* СТ-15/214  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма, Б.Ариунжаргал, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл  
*Огноо:* 2015.04.06  
*Сэдвийн агуулга:* Хүүхдэд асран хамгаалах эцэг, эхийн хариуцлагын тухай эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын болон гадаадын зарим орны тухайлбал, ХБНГУ, Норвеги, Англи, Ирландын холбогдох хууль эрх зүйн орчныг судлан харьцуулан судалсан болно.

### ТӨРИЙН АЛБАНААС ТЭТГЭВЭРТ ГАРАХ НАСЫГ ТОГТООДОГ ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

*Судалгааны код:* СТ-15/402  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Д-р Г.Алтан-Оч, И.Жаргалзаяабямба, Б.Ариунжаргал  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Г.Батхүү  
*Огноо:* 2015.01.15  
*Сэдвийн агуулга:* Гадаад орнуудын төрийн албаны холбогдолтой судалгаануудад үндэслэн төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэврийг хэдэн насаар тогтоодог, хүн амын дундаж наслалт ямар байгаа талаар дэлхийн бүх орноор статистик мэдээлэл гаргаж, Монгол Улсын хүн амын дундаж наслалтын 2013 оны түвшинг өмнөх 10 жилийн байдалтай харьцуулан судалсан болно.

### ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА

*Судалгааны код:* СТ-15/418  
*Судалгааны төрөл:* Лавлагаа, мэдээлэл  
*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн С.Эрдэнэ  
*Огноо:* 2015.05.26  
*Сэдвийн агуулга:* Их Британи, Энэтхэг, Австрали, АНУ, ОХУ зэрэг орнуудад “Тэтгэврийн зээлийн тухай” хуулийн ерөнхий зохицуулалт, хэрэгжилтийг хэрхэн хангадаг талаарх туршлагыг харьцуулан лавлагаа, мэдээлэл бэлтгэсэн болно.

## ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ САЛБАРЫН БОДЛОГО

### УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРЬСАН “ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БУСАД ОРНЫ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУДТАЙ ХАРЬЦУУЛАН СУДАЛГАА

<i>Судалгааны код:</i>	СТ-15/201
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Билгээ, Д.Жигваагүнсэл, Д.Халиун
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн, ЭЗБХ-ны дарга Б.Гарамгайбаатар
<i>Огноо:</i>	2015.01.14
<i>Сэдвийн агуулга:</i>	<p>Засгийн газраас УИХ-д 2014.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг гадаадын бусад орнуудын чөлөөт бүсийн тухай хууль, эрх зүйн зохицуулалттай харьцуулахыг зорив.</p> <p>Судалгаанд БНАрмен улс, БНБеларусь улс, БНКазахстан улс, БНСерби улс, БНСолонгос улс, БНТурк улс, БНХАУ, Малайзын ХУ, ОХУ зэрэг 9 орны хуулиудыг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа Чөлөөт бүсийн тухай хуулийн төсөл болон одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Чөлөөт бүсийн тухай хуультай (2002 он) харьцуулахдаа Чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой гол харилцааг бүлэглэн, тухайн асуудлыг хэрхэн зохицуулсан талаар тоймлон судалсан болно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. хууль, эрх зүйн орчин,</li><li>2. Чөлөөт бүсийн тухай тодорхойлолт (Хүснэгт 1),</li><li>3. Чөлөөт бүсийг үүсгэн байгуулах, татан буулгах (Хүснэгт 2),</li><li>4. Чөлөөт бүс дэх тусгай дэглэм (Хүснэгт 3),</li><li>5. санхүүжилт, татвар, газрын харилцааны зохицуулалт (Хүснэгт 4),</li><li>6. удирдлага болон оролцогчийн эрх, үүрэг (Хүснэгт 5)</li></ol> <p>зэрэг асуудлыг хуулиар хэрхэн зохицуулсныг хүснэгтээр үзүүлэв.</p>

### МОНГОЛ УЛСАД БОЛОН ГАДААДЫН УЛС ОРНУУДАД ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН АСУУДЛЫГ ЭРХ ЗҮЙН ТАЛААС НЬ ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ, ЗАРИМ ЖИШИГ

<i>Судалгааны код:</i>	СТ-15/203
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Б.Ариунжаргал, Р.Нургул, Г.Чулуун
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн С.Ганбаатар
<i>Огноо:</i>	2015.02.28
<i>Сэдвийн агуулга:</i>	<p>Газар өмчлөлийн асуудлын хууль эрхзүйн үндсийг лавлах чиглэлд өгөгдсөн нэр бүхий сэдвүүдийн хүрээнд энэхүү судалгааг бэлтгэв. Захиалагч тал “газар өмчлөл, газар хувьчлалын асуудал”-ыг тухайлан сонирхсон тул, мэдээлэлд, газрыг өмчийн талаас нь лавшруулж харахыг чухалчилсан. Газар бол, нэг талаас байгалийн объект тул, түүнд байгаль хамгааллын үүднээс хандах, газар өөрөө үйлдвэрлэлийн хэрэгсэл тул түүнтэй хэрхэн харьцах ёстойг “заах чиглүүлэх”, мөн газар нь үл хөдлөх хөрөнгө тул өмчлөгчийн эрхийг хамгаалах асуудуудыг цогцоор харах .. олон уулзвар дээр газрын харилцааны асуудал зохицуулагддагийг судалгаанд тоймлон өгүүлжээ. Судалгаа,</p>

- A. Монгол Улсын газрын харилцааны хууль тогтоомж дах газар өмчлөлийн холбогдолтой “тодруулбал зохих” зарим асуудал (судл. реф. Г.Чулуун)
- B. Гадаадын зарим орны газар өмчлөлийн эрх зүйн зохицуулалтын зарим онцлог (судл. реф. Р.Нургүл, Б.Ариунжаргал) гэсэн 2 хэсэг [нийт 29 хуудас мат.] –ээс бүрдэнэ.

## **МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ТАТВАРЫН ТОГТОЛЦОО**

*Судалгааны код:* СТ-15/204  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн С.Оюун  
*Огноо:* 2015.02.04  
*Сэдвийн агуулга:* Монгол Улсын уул уурхайн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын тогтолцоо, хувь хэмжээ, уул уурхайн салбараас улсын төсөвт оруулж буй орлогын хэмжээ, татварын ачаалал зэрэг тоон мэдээлэл болон гадаадын зарим орны уул уурхайн салбарын татварын хувь хэмжээ, зарим улс орны хууль тогтоомжид 2014-2015 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар судалсан болно.

## **ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ, ШИНЭЭР ХӨГЖЛИЙН ТӨВ БАЙГУУЛАХ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ТУШЛАГА**

*Судалгааны код:* СТ-15/219  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Алтан-Оч, Г.Билгээ, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Ганхуяг  
*Огноо:* 2015.05.05  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд ОХУ-ын Санкт-Петербург хот, БНХАУ-ын Шанхай хот, БНСУ-ын Пусан хот, Бүгд Найрамдах Казахстан Улс, Канадын Торонто хотуудын үүсэж хөгжсөн түүх, хөгжлийн явц, хөгжлийн бодлого болон төвлөрлийг сааруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн төрийн бодлого, эдийн засгийн хөшүүрэг зэрэг асуудлыг судалсан болно.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УУЛ УУРХАЙН БАЯЛГИЙН САНГИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-15/429  
*Судалгааны төрөл:* Лавлагаа мэдээлэл  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Онончимэг, Б.Нандингэрэл, О.Нарантуяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн С.Ганбаатар  
*Огноо:* 2015.10.26

*Сэдвийн агуулга:*

Уул уурхайн баялагтай улс орнуудын тухайн салбарт баримталдаг баялгийн зөв зохистой зохицуулалт, эрх зүйн туршлага, хэрэгжүүлж буй загварын талаарх харьцуулсан судалгааг гүйцэтгэсэн. Нэгдүгээр хэсэгт эрсдэлийн сангуудын тухай ойлголт, төрөл хэлбэрүүд болон одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн баялгийн сангуудын статистик мэдээлэл, хоёрдугаар хэсэгт уул уурхайн салбарт баялгийн санг амжилттай хэрэгжүүлсэн Норвеги, Канад, Австрали, Чили, Азербайжан зэрэг орнуудыг сонгон авч тухайн улсын уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд баримталсан төрийн бодлого, баялгийн сангийн зохицуулалт, ашиглалт болон түүний зөв зохистой зарцуулалтын талаар мэдээлэл, лавлагаа бэлтгэсэн болно.

## ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, ГАДААД БОДЛОГО

---

### ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ ЗАРИМ ОРОНД ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙГ ХЭРХЭН ТОМИЛДОГ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Судалгааны код:* СТ-15/205  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма, Г.Билгээ, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Г.Батхүү  
*Огноо:* 2014.02.16  
*Сэдвийн агуулга:* Парламентын засаглалтай зарим оронд Төрийн албаны зөвлөлийн дарга болон гишүүдийг томилох хууль эрх зүйн зохицуулалтыг 18 орны жишээн дээр, тухайн улсын Үндсэн хууль, Төрийн ба Нийтийн албаны тухай хуулийн зохицуулалтыг харьцуулан судалсан болно.

### УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДСЭН ИРГЭДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Судалгааны код:* СТ-15/207  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл  
*Огноо:* 2014.03.10  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга О.Баасанхүү  
*Сэдвийн агуулга:* Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлын эрх зүйн зохицуулалт, нөхөн олговор авах эрх бүхий этгээдийг тогтоох, ямар хэмжээний олговрыг хэрхэн олгодог талаар Монгол Улсын болон ОХУ, Казахстан, Болгар, Польш зэрэг орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсан болно.

### ДЭЭД ШҮҮХИЙН ХУУЛИЙН ТАЙЛБАР ХИЙХ БҮРЭН ЭРХИЙН ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Судалгааны код:* СТ-15/409  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч, Б.Ариунжаргал, А.Пагма  
*Огноо:* 2015.04.22  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ХЗБХ-ын дарга Д.Ганбат  
*Сэдвийн агуулга:* ХБНГУ, ОХУ, Латви улсуудын дээд шүүхийн хууль тайлбарлах бүрэн эрх, тайлбарын агуулга, төрөл, хэлбэрийн талаар товч лавлагаа мэдээлэл бэлтгэсэн болно.

### ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Судалгааны код:* СТ-15/221  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Жигваагүнсэл, И.Жаргалзаяабямба, Ө.Мөнхтунгалаг  
*Огноо:* 2015.05.13  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Захиалагчийн хүсэлтийн дагуу Бүгд Найрамдах Турк Улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, гишүүдийг хэрхэн томилдог талаарх эрх зүйн зохицуулалт, Мексик, Бүгд Найрамдах Колумб улсуудын шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн зохицуулалтын тойм, Латин Америкийн нийт 15 улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг, гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацааны талаар харьцуулсан судалгаа хийсэн болно.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ДЭГИЙГ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ**

*Судалгааны код:* СТ-15/223  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма, Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, О.Нарантуяа, Б.Нандингэрэл, Д.Халиун  
*Огноо:* 2015.11.11  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд ХБНГУ, Норвеги, Франц, Австрали, Канад зэрэг орнуудад Парламентын хэлэлцүүлэг болон мэтгэлцээний дэг, үйл явц болон хэлэлцүүлэг, мэтгэлцээнд үг хэлэх хугацааг Дэгийн тухай хуулиар хэрхэн зохицуулсныг авч үзлээ.

## **БАЙНГА ТӨВИЙГ САХИХ СТАТУСТАЙ УЛСУУД: ТУРШЛАГА, СУРГАМЖ**

*Судалгааны код:* СТ-15/224  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма, Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл  
*Огноо:* 2015.11.28  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ж.Энхбаяр  
*Сэдвийн агуулга:* УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны захиалгаар гүйцэтгэсэн тус судалгаанд байнгын төвийг сахих статусаа зарласан улс орнуудын тухай ерөнхий мэдээлэл, түүнчлэн Австри, Швейцар болон Туркменистан улсын туршлага, түүхэн сургамжийг судалсан болно.

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ (1992) БА МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗЫН ТӨСЛҮҮДИЙН (1991.VI.05, X.05, XI.07) ХАРЬЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-15/206  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Билгээ, Д.Жигваагүнсэл



*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Огноо:* 2014.02.04  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийг Монгол Улсын Их цаазын төслүүдэд хэлэлцүүлэгийн явцад хэрхэн өөрчлөгдсөн харьцуулалт хийж, тодорхой тэмдэглэгээгээр тэмдэглэсэн. Энэхүү харьцуулсан судалгаанд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулиас гадна Улсын Бага хуралд өргөн барьсан хуулийн төсөл (1991.VI.05), ард түмнээр хэлэлцүүлүүлэхээр “Ардын эрх” сонинд хэвлэгдсэн хуулийн төсөл (1991.06.05), засвар хийж дахин Улсын Бага хуралд өргөн барьсан хуулийн төсөл (1991.10.05), Улсын Бага хурлаас Ардын их хуралд өргөн барьсан хуулийн төслийг (1991.11.07) хамруулсан болно.

## **ПАРЛАМЕНТЫН ЭЭЛЖИТ БУС СОНГУУЛИЙГ ЗАРЛАХ ТУХАЙ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-15/208  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч, Г.Чулуун, Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа  
*Огноо:* 2014.03.13  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Тус судалгаагаар Парламентын–8, Үндсэн хууль хаант засагтай–8, Ерөнхийлөгчийн–4, хагас Ерөнхийлөгчийн–13, Эзэн хаант тогтолцоотой – 1 нийт 34 орны Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид Парламентын ээлжит бус сонгууль явуулахтай холбоотой асуудлыг хэрхэн зохицуулсныг судалсан болно.  
Судалгаанаас үзвэл нийт 34 орны дараах субъект: Ерөнхийлөгч–17, Хаан–4, Ерөнхий сайд–1, Үндэсний зөвлөлийн дарга–1, Засгийн газар–1 ээлжит бус сонгууль зарлах эрхтэй байгаа бол хоёр улс нь Парламентын ээлжит бус сонгууль явуулдаггүй байна.

## **ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР СОНГОГДОХ НАСНЫ ДООД ХЯЗГААР**

*Судалгааны код:* СТ-15/209  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Билгээ  
*Огноо:* 2014.03.13  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд 64 орныг хамруулсан ба эдгээр улсуудаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн насны дээд хязгаарыг 50 нас (Итали) гэж тогтоосон бол насны доод хязгаарыг 18 нас (Швейцарь), 21 нас (Иран), 25 нас (Венесуэл, Никарагуа, Сан Марино) гэж тус тус тогтоосон байна. Харин Франц улсын хувьд Ерөнхийлөгчөөр сонгогдох насны ямар нэгэн хязгаарыг тогтоогоогүй байна.

## **ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХҮН АМЫН ТООГ ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ТООНД ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

*Судалгааны код:* СТ-15/210

*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Билгээ, Б.Ариунжаргал  
*Огноо:* 2014.03.13  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд нийт 191 улс орныг хамруулсан бөгөөд тухайн улсын хүн амын тоог парламентын танхимын гишүүний тоонд (үүнд нэг танхимтай парламентын гишүүдийн тоо, эсвэл хоёр танхимтай парламентын хувьд доод танхимын гишүүдийн тоог баримталсан) харьцуулан гаргасан.

## **ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ ОРНУУДЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО БА РОТАЦИЙН ЖУРМААР ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙГ СЭЛГЭДЭГ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-15/211  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Ө.Мөнхтунгалаг  
*Огноо:* 2014.03.13  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд авагдсан 60 орноос нийт 17 улс парламентын гишүүдийг ротацийн журмаар шинэчлэдэг ба эдгээрээс 4 улс нь парламентын засаглалтай, 13 улс нь ерөнхийлөгчийн засаглалтай байна.

## **ХОЛБООНЫ УЛСУУДЫН ПАРЛАМЕНТЫН ТАНХИМЫН ТОО**

*Судалгааны код:* СТ-15/212  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Билгээ, Б.Ариунжаргал  
*Огноо:* 2014.03.13  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд хамрагдсан нийт 191 улсын 27 нь холбооны улс бөгөөд үүнээс хоёр танхимтай холбооны улс 20 (Австрали, Австри, АНУ, Аргентин, Бельги, Босни Герцеговин, Бразил, Герман, Ирак, Канад, Малайз, Мексик, Мьянмар, Нигерия, ОХУ, Пакистан, Судан, Швейцарь, Энэтхэг, Этиоп), нэг танхимтай холбооны улс 7 (Арабын НЭУ, Венесуэл, Коморын арлууд, Микронез, Сент-Китс ба Невис, Сомали, Танзани) байна.

## **ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНУУДЫН ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА**

*Судалгааны код:* СТ-15/401  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Билгээ, Д.Жигваагүнсэл  
*Огноо:* 2015.02.16  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг

*Сэдвийн агуулга:* Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу дэлхийд Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээгээр тэргүүлэгч 15 орон болон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр тэргүүлэгч 10 орны төрийн байгуулал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглалын талаарх мэдээлэл, эрх зүйн системийн аль бүлд хамаардаг тухай мэдээлэл лавлагаа бэлтгэв. Судалгаанд төрийн байгууллын хувьд Үндсэн хуульт хаант засаглалтай –12 орон, Үндсэн хуульт парламентын засаглалтай–8 орон, Ерөнхийлөгчийн засаглалтай–5 орныг хамруулав.

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ (1992) БА МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗЫН ТӨСЛҮҮДЭД (1991.VI.05, X.05, XI.07) ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯВЦАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД**

*Судалгааны код:* СТ-15/403  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Билгээ, Д.Жигваагүнсэл  
*Огноо:* 2015.02.05  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* 1-р төсөл– Монгол улсын их цааз (Үндсэн хууль), Улсын Бага Хуралд өргөн барьсан хувь, 1991.04.19.  
2-р төсөл–Монгол улсын Их цааз (Үндсэн хууль), Ард түмнээр хэлэлцүүлсэн хувь, 1991.06.05.  
3-р төсөл–Монгол улсын Үндсэн хууль (Их цааз), Улсын Бага Хуралд өргөн барьсан хувь, 1991.10.05.  
4-р төсөл–Монгол улсын Их цааз, Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд өргөн барьсан хувь, 1991.11.07. төслүүдийг 1992 онд батлагдсан Үндсэн хуультай харьцуулан хасагдсан зүйл, заалтууд болон өөрчлөлт орсон зүйл заалтуудыг харьцуулсан болно.

### **БОЛГАР УЛСЫН ТӨРИЙН ТОГТОЛЦОО, СОНГУУЛИЙН СИСТЕМ, 2009 ОНЫ СОНГУУЛЬ БОЛОН ЕВРОПЫН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-15/407  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Жигваагүнсэл  
*Огноо:* 2015.02.17  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Болгарын төрийн тогтолцоо, сонгуулийн системийн талаарх товч мэдээлэл болон Болгарын парламентын 2009.07.05-нд зохион байгуулагдсан сонгуулийн үр дүн, Европын парламентын сонгуулийн үр дүнгээр мэдээлэл лавлагаа бэлтгэсэн болно.

### **ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНЭЭР СОНГОГДОХ НАСНЫ ДООД ХЯЗГААР**

*Судалгааны код:* СТ-15/215  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Билгээ  
*Огноо:* 2015.04.24  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Батбаяр  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд парламентын засаглалтай 29 орныг хамруулсан бөгөөд эдгээр улсуудад Парламентын сонгуульд нэр дэвшигчийн насны доод хязгаар хэрхэн тогтоосныг дараах хүснэгтэд оруулсан болно.

### **ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНУУДЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-15/216  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч, Б.Ариунжаргал, Г.Билгээ, Д.Жигваангүнсэл, И.Жаргалзаяабямба, Р.Нургүл, Ө.Мөнхтунгалаг, Г.Чулуун, Ч.Онончимэг, Д.Халиун, А.Пагма Ц.Элбэгзаяа  
*Огноо:* 2015.04.24  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд дэлхийн 40 орныг хамруулж, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох, Засгийн газрын гишүүдийг томилох харилцааг хэрхэн зохицуулдаг талаар судалсан болно.

### **ТӨРИЙН ТЭРГҮҮНЭЭР СОНГОГДСОН ТОХИОЛДОЛД УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛЭЭС ТАТГАЛЗАХ БОЛОН ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-15/217  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Д.Жигваангүнсэл, И.Жаргалзаяабямба, Р.Нургүл, Ө.Мөнхтунгалаг, Г.Чулуун, Ч.Онончимэг, А.Пагма Ц.Элбэгзаяа  
*Огноо:* 2015.04.28  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Батбаяр  
*Сэдвийн агуулга:* Дэлхийн улс орнуудад ерөнхийлөгчийн эрх мэдэл хоорондоо их ялгаатай. Тухайлбал, АНУ-д ерөнхийлөгч нь төрийн тэргүүнээс гадна засгийн газрын тэргүүн байдаг бол Германд ерөнхийлөгч нь зөвхөн төрийн тэргүүн, засгийн газраа толгойлохгүй. Иймд ерөнхийлөгчийн намын гишүүнчлэл нь зөвхөн төрийн тэргүүн үү, эсвэл засгийн газраа толгойлох уу гэдгээс хамаарна. Дэлхийн нилээд олон орны Үндсэн хуулинд ерөнхийлөгчийг улс төрийн намын үйл ажиллагаанд оролцохыг хориглосон байдаг байна. Энэхүү судалгаанд намын гишүүнчлэлээс татгалздаг 24 орны эрх зүйн зохицуулалтыг судалсан.

### **ГАДААД ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ БА ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХАРЬАЛЛЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА**

*Судалгааны код:* СТ-15/218  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Б.Ариунжаргал, Д.Жигваангүнсэл, И.Жаргалзаяабямба, Р.Нургүл, Ө.Мөнхтунгалаг, Г.Чулуун, Ч.Онончимэг, А.Пагма, Ц.Элбэгзаяа  
*Огноо:* 2015.04.24

**Захиалагч:** УИХ-ын Ажлын хэсэг  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд нийт 25 орныг Үндсэн хуулийн шүүх ба прокурорын байгууллагын харьяаллын талаарх хууль, эрх зүйн орчны лавлагаа бэлтгэсэн.

## **ХБНГУ-ЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, ХОЛБООНЫ КАНЦЛЕР, ХОЛБООНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТУХАЙ ЗАРИМ ЗААЛТУУД**

**Судалгааны код:** СТ-15/410  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл, лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар  
**Огноо:** 2015.04.24  
**Захиалагч:** УИХ-ын Ажлын хэсэг  
**Сэдвийн агуулга:** ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ-ийн 54-93 дугаар зүйл заалтыг албан бус орчуулгаар бэлтгэсэн.

## **ИХ БРИТАНИ, ИЗРАЙЛИЙН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ДҮН – 2015**

**Судалгааны код:** СТ-15/411  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, А.Пагма  
**Огноо:** 2015.05.11  
**Захиалагч:** УИХ-ын Ажлын хэсэг  
**Сэдвийн агуулга:** 2015.05.07-нд болсон Их Британийн парламентын сонгуулийн дүн болон 2015.03.17-ны өдрийн Израйльд болсон парламентын ээлжит бус сонгуулийн дүнгийн талаар авч үзсэн болно.

## **ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО**

**Судалгааны код:** СТ-15/412  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Д.Халиун  
**Огноо:** 2015.05.16  
**Захиалагч:** УИХ-ын Ажлын хэсэг  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд нийт 187 улс орнуудын засаглалын тогтолцоог дэлгэрэнгүй хэлбэрээр авч үзсэн болно. Үүнд: Ерөнхийлөгчийн засаглалтай 86 орон, Парламентын засаглалтай 50 орон, Хаант засаглалтай 44 орон, Нэг намын засаглалтай 7 орон болно.

## **ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО**

*(Монгол Улстай адил Ерөнхийлөгч болон Парламентын гишүүдийг бүх ард түмний сонгуулиар сонгодог улс орон бий эсэх талаарх лавлагаа)*

**Судалгааны код:** СТ-15/413  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Д.Халиун

*Огноо:* 2015.05.16  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Судалгааг 2 хэсэгтэй хийсэн бөгөөд 1-р хэсэгт Парламентын засаглал бүхий 50 орноор Ерөнхийлөгч болон Парламент /Хууль тогтоох дээд байгууллага/-ыг хэрхэн сонгодог талаарх мэдээллийг, 2-р хэсэгт дэлхийн 226 оронд Ерөнхийлөгч болон Парламент /Хууль тогтоох дээд байгууллага/-ыг хэрхэн сонгодог, сонгуулийн төрөл, Хууль тогтоох дээд байгууллага /Парламент/-ын сонгуулийн тогтолцоо, гишүүдийн тоо болон санал өгөх эрх бүхий гишүүдийн тоо зэрэг мэдээлэл лавлагааг бэлтгэлээ.

## **МОНГОЛ УЛСТАЙ ИЖИЛ ТӨСТЭЙ ЗАРИМ ОРНЫ ЗАСАГЛАЛЫН БОЛОН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО, СОНГУУЛИЙН ХЭЛБЭРИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-15/414  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Д.Халиун  
*Огноо:* 2015.05.18  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Ерөнхийлөгч, Парламентыг /парламентын нэг танхимтай/ бүх нийтээр сонгодог Монгол Улстай ижил төстэй сонгуулийн тогтолцоо бүхий 15 улс байна. Үүнд: Болгар, Исланд, Кирибати, Кыргызстан, Литва, Македон, Монгол, Сингапур, Серби, Словак, Турк, Финланд, Хорват, Чрна Гора, Эстони зэрэг болно. Эдгээрээс Ерөнхийлөгчийг сонгох хэлбэр, Парламентын танхимын тоо, Засгийн газрын тэргүүнийг томилох хэлбэрээр нь Монгол Улстай ижил төстэй зохицуулалт бүхий орнуудыг шүүн үзэхэд Болгар, Финланд, Серби, Чрна Гора /Монтенегро/ зэрэг 4 орон байна. Эдгээр орнуудыг эрх зүйн систем, засаглалын тогтолцоо, Парламентыг сонгох хэлбэр болон Засгийн газрыг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалт зэргээр нь нарийвчлан авч судалсан болно.

## **БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-15/423  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ө.Мөнхтунгалаг  
*Огноо:* 2015.06.19  
*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Бүгд Найрамдах Сингапур Улсын засаг захиргааны нэгжийн бүтэц, зохион байгуулалтын талаарх тойм мэдээлэл бэлтгэв.

## **2000 ОНД МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН 7 НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНТЭЙ ИЖИЛ ТӨСТЭЙ БУСАД ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-15/213  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч, Б.Ариунжаргал, Г.Билгээ,  
И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл,  
Ч.Онончимэг, А.Пагма, Д.Халиун, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа

*Огноо:* 2015.02.27

*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг

*Сэдвийн агуулга:* Монгол Улсын Үндсэн хуульд 2000 онд оруулсан 7 нэмэлт, өөрчлөлт, түүнтэй ижил төстэй зохицуулалтыг бусад орнуудын /дэлхийн 50 орны/ Үндсэн хуулиар хэрхэн зохицуулсныг харьцуулан лавлагаа мэдээлэл бэлтгэв.

## **БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА**

*Судалгааны код:* СТ-15/415

*Судалгааны төрөл:* Лавлагаа мэдээлэл

*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма, Д.Жигваагүнсэл,

*Огноо:* 2015.05.27

*Захиалагч:* УИХ-ын Ажлын хэсэг

*Сэдвийн агуулга:* Судалгаанд БНМАУ-ын Ардын Их Хурлын үйл ажиллагааны үндсийг хуульчилсан эрх зүйн баримт бичгүүд, БНМАУ-ын төрийн эрх барих байгууллагуудын тогтолцоо, БНМАУ-ын Ардын Их Хурлын ээлжит сонгууль явагдсан он дараалал, БНМАУ-ын сум, хороо, район, орон нутгийн, хотын Ардын Депутатуудын Хурлын сонгууль явагдсан он дарааллын талаарх лавлагаа, мэдээллийг бэлтгэв.